



ҮЙЛ ЯВДАЛ

“Олон улсын болон үндэсний хэмжээнд авлига, мөнгө угаах явдалтай тэмцэх нь” сургалтыг зохион байгуулав



Авлигатай тэмцэх газар, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага хамтран “Олон улсын болон үндэсний хэмжээнд авлига, мөнгө угаах явдалтай тэмцэх нь” сургалтыг 2017 оны 9 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд зохион байгууллаа.

Сургалтад прокурорууд, Авлигатай тэмцэх газрын болон Цагдаагийн ерөнхий газрын мөрдөн байцаагч нар, Монголбанкны албан хаагчид оролцож, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Интерпол, Их Британийн Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх албаны мэргэжилтнүүд сургалтыг явуулж, харилцан мэдлэг, туршлагаа солилцов.

Уг сургалтыг Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал нээж хэлсэн үгэндээ, асар хурдацтай хөгжил дэвшил, даяаршлын энэ цаг үед аливаа улс орон ганцаараа оршиж чадахгүйн адил нэг улс орон дангаараа авлигатай бүрэн тэмцэж чадахгүй. Иймээс ямар ч улс орны авлигатай тэмцэх байгууллага бусад улс орон, олон

улсын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, алба хаагчдынхаа мэргэжлийн ур чадварыг байнга дээшлүүлж, гадаадын улс орнуудын сайн туршлагаас судалж, хэрэгцээт зүйлийг олж, өөрсдийн ажил албандаа авч хэрэгжүүлж байх нь маш чухал болохыг онцлон тэмдэглээд мөрдөн шалгах аргачлал, албан болон албан бусаар мэдээлэл олж авах, эрх зүйн туслалцааны хүсэлт, олон улс, бүс нутаг болон улс орны авлигатай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран ажиллах чиглэл зэрэг онц сонирхолтой, өндөр ач холбогдолтой сэдвүүдийг судлах энэ удаагийн сургалтад идэвхтэй оролцож, үр өгөөжтэй хамтран суралцахыг оролцогчдоос хүсэв.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Эдийн засгийн зөвлөх, ноён Роел Жансенс “Олон улсын хамтын ажиллагаа нь авлигатай тэмцэх үйл хэрэгт маш чухал нөлөөтэй.

Төгсгөл нь II нүүрт

Оффшор бүсэд байршуулсан мөнгө Монгол Улсад орж эхэллээ

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс явуулсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд нийтэд зарлагдсан оффшор бүсээс Монгол Улсын иргэн 4 сая 370 мянган ам.доллароо Монгол Улсад оруулж ирлээ. Энэ бол оффшор бүсэд байршуулсан мөнгөн хөрөнгийг буцаан татсан хамгийн анхны тохиолдол юм.

Монгол Улсын иргэд оффшор бүсэд данс нээж, ажахуйн нэгжүүсгэн байгуулсан гэх асуудлыг Улсын ерөнхий прокурорын тогтоолоор байгуулагдсан Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан ажлын хэсэг Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж байгаа билээ.



МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Прокурорууд, мөрдөгч нар, санхүүгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулав



Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Хоёр өдрийн турш та бид харилцан туршлага судалж, мэдээлэл солилцож, хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэх боломж олдож байна. Бид онц залилангийн гэмт хэрэгтэй хэрхэн тэмцэж байгаа чиглэлээр Их Британийн туршлагыг судална. Мөнгө угаах нь нарийн түвэгтэй бөгөөд нэг улс дангаараа тэмцээд дийлэхгүй явдал юм. Олон улсын төдийгүй олон талын хамтын ажиллагаа байдаг учраас прокурор, авлигатай тэмцэх болон цагдаа, мөн төв банкны албан хаагчдад энэ сургалтыг зориулж байна” гэж хэллээ.

Сургалтыг Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Эдийн засгийн зөвлөх, ноён Роел Жансенс, Их Британийн Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх албаны ахлах мөрдөн байцаагч, хатагтай Жэнифер Брачнер, Интерполын Авлигын гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээний мэргэжилтэн, ноён Эрнэсто Андрес Гранадос Гозалис нар хийв. Тэд авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, яллахтай холбоотой олон улсын стандарт, зарчмууд, заавар зөвлөмж, авлигын гэмт хэргийн улмаас олсон ашгийг хураан авахтай холбоотой дотоодын болон олон улсын зохицуулалтыг зөв ашиглах, хууль бус хөрөнгийг олж тогтоон, буцаан авчрахтай холбоотой олон улсын хамтын ажиллагааг зохион байгуулах, санхүүгийн болон авлигын гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой хамтын ажиллагааны эрх зүйн орчин, практикийн асуудлууд, ялтан шилжүүлэх, хөрөнгийг буцаан авах ажиллагаа, эрх зүйн туслалцааны хүсэлт боловсруулахад бэлтгэх, нээлттэй эх сурвалжаас мэдээлэл цуглуулах зэрэг

сэдвүүдээр ярилцаж, мэдээлэл солилцлоо.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Эдийн засгийн зөвлөх, ноён Роел Жансенс сургалтын төгсгөлд хэлэхдээ Монгол Улс оффшор бүсийн асуудлаар тодорхой санал санаачилга гарган ажиллаж байгааг тэмдэглэв.

Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал сургалтыг хааж хэлсэн үгэндээ “Энэхүү сургалтаар бидний сонссон туршлага, мэдээлэл нь Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах зорилтыг хэрэгжүүлэхэд бүрэн нийцэж байгаа юм. Авлигатай тэмцэх үйл хэргийг олон нийтийн хяналтад оруулж, тэдний тусламжтайгаар бусад хөгжингүй орны түвшинд хүргэх томоохон зорилтыг бид өмнөө тавиад байна. Үүний дагуу бид өнгөрсөн онд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлуулсан. Цаашид бид “Зүүн өмнөд Азийн бүсийн сургалтын төв” байгуулахаар ажиллаж байгаа. Энэ талаар Авлигын эсрэг академи дэмжиж хамтран ажиллахаа илэрхийлснийг онцлон хэлмээр байна. Эдгээр томоохон зорилтуудын маань анхны алхам, эхлэл нь энэ сургалт болж, энэ үйл хэргийн төлөө бид нэгдмэл байж хамтдаа тэмцэх юм шүү гэдгээ ярилцаж тогтлоо. Бидний уулзах ёстой цэг энэ төв юм гэдэг сэтгэгдлийг та бүхэнд төрүүлсэн байх гэж найдаж байна. Сургалтаар олж авсан мэдлэг, мэдээлэл цаашид бодит, үр дүнтэй ажил хэрэг болгохын төлөө Авлигатай тэмцэх газрын албан хаагчид чармайж ажиллана” гэв.

2017.09.21.

Яам, агентлагуудыг шалгасан дүнг хэлэлцүүлж эхэллээ

Авлигатай тэмцэх газраас яам, агентлагууд дахь авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцсан дүнгээ 2017 оны 9 дүгээр сарын 24-ний өдрөөс хэлэлцүүлж эхэллээ.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлан таниулах хүрээнд тус газрын даргын тушаалаар томилогдсон Ажлын хэсгүүд 13 яам, 27 агентлагт өнгөрсөн хавар ажиллах хугацаандаа иргэдээс гомдол мэдээлэл хүлээн авч, авлигын эрсдлийн үнэлгээ хийсэн юм. Ажлын хэсгүүдийн яам, харьяа агентлагуудын 2015-2017 оны хугацаанд авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн шалгалтын дүнгээ хэлэлцүүлсэн тухай мэдээллийг V нүүрээс хүлээн авч уншаарай.

Зөвлөмжийн хэрэгжилтийг

олон улсад тайлагнав

Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Т.Баярхүү Франц Улсын Парис хотод 2017 оны 9 дүгээр сарын 12-14-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Эдийн засаг, хамтын ажиллагааны байгууллагын Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний уулзалтад оролцож, тус сүлжээнээс гаргасан зөвлөмжүүдийн хүрээнд Монгол Улсаас авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар тайлагналаа.

Уг уулзалтад Армени, Азербайжан, Гүрж, Киргиз, Казахстан, Тажикистан, Монгол, Украин, Узбекистан зэрэг улс орноос төлөөлөгчид оролцож, авлигатай тэмцэх, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр хийсэн ажлаа тайлагнахын зэрэгцээ олсон амжилт, сайн туршлагынхаа талаар танилцуулав.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний уулзалт нь тус байгууллагын Хээл хахуультай тэмцэх албаны ажлын хэсгийн боловсруулсан авлигатай тэмцэх бүс нутгийн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагддаг. Авлигын эсрэг сүлжээ нь авлигын эсрэг арга хэмжээний үйл явцтай холбоотой бүс нутгийн уулзалт зохион байгуулж, харилцан мэдээлэл солилцох, туршлагыг түгээх, санхүүжүүлэгчдийн үйл ажиллагааг зохион байгуулах замаар Зүүн Европ болон Төв Азийн улс орнуудад авлигатай тэмцэх үйл хэрэгт дэмжлэг үзүүлдэг юм.

ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ

З.БААСАННЯМ: МАНАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖИЙГ ХҮЛЭЭН АВЧ ХАМТРАН АЖИЛЛАХАД ТАТГАЛЗАХ ЗҮЙЛ БИДЭНД БАЙХГҮЙ

Хэвлэлийн хурал хийлээ

Авлигатай тэмцэх газрын даргын баталсан журмын дагуу тус газар сар бүрийн 25-ны өдөр иргэд, олон нийтэд зориулан үйл ажиллагааны мэдээллээ тогтмол хүргэж байхаар болсон билээ.

Энэ удаагийн хэвлэлийн бага хуралд Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Т.Баярхүү, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Х.Хашбаатар, Мөрдөн байцаах албаны дарга, ахлах комиссар Н.Дамдинсүрэн нар оролцож, 2017 оны 9 дүгээр сард хийж гүйцэтгэсэн ажил, Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны талаар сэтгүүлчдэд мэдээллээ.

Хэвлэлийн бага хурлын үеэр сэтгүүлчдийн асуултад Авлигатай тэмцэх газрын хэлтэс, албадын дарга нар хэрхэн хариулсныг товчоор хүргэе.

www.news.mn: -Цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит компанитай холбоотой хэргийн талаар мэдээлэл өгөхгүй юу? Төмөр замын хэрэгт хэд хэдэн хүнийг холбогдуулан шалгаж байгаа. Прокуророос 2-3 хүнийг нь яллагдагчаар татахаас татгалзсан гэсэн мэдээлэл өгсөн. Мөрдөн байцаалтын ажиллагаа эргээд үргэлжлэх боломжтой юу? Энэ талаар мөн мэдээлэл өгнө үү. Шинээр хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулиар тухайн хэргийг мөрдөн байцаах хугацаа хэдэн жилээр байдаг вэ?

Мөрдөн байцаах албаны дарга, ахлах комиссар Н.Дамдинсүрэн: -Цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит компанид холбогдох хэрэгт нэр бүхий 3-4 хүнийг шалгаж байгаа. Удирдлагуудтай нь холбоотой хэрэг. Урьд нь мэдээлэгдэж байсан байх.

Төмөр замын хэргийн талаар Нийслэлийн прокурорын газраас мэдээлэл өгсөн байгаа. Тодорхой хэргийг хэрэгсэхгүй болсон үйлдэл, холбогдлыг нэлээд дэлгэрэнгүй танилцуулсан. Энэ хэрэг дээр Зам, тээврийн сайд асан А.Гансүх болон Солонгосын "Самсунг С&Т" компанийн холбогдох



хэргийг шүүхэд шилжүүлэх саналтайгаар прокурорт манайхаас шилжүүлсэн. Одоо Монголын төмөр замын гүйцэтгэх захирал, Зам тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Б.Батзаяа нарт холбогдох хэргийг тусгаарлан мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа. Тэгэхээр мөрдөн байцаалтын ажиллагааг тасралтгүй явуулж байгаа гэж ойлгож болно.

"Өдрийн сонин": -60 тэрбум төгрөгийн хэрэг дээр танайх мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан юм билээ. Гэхдээ "Чи төрийн албанд орохдоо мөнгө өгсөн үү, өгөөгүй юу" гэдэг тайлбарыг аваад л хэргийг хаачихсан гэсэн нэг мэдээлэл яваад байна. Энэ талаар тайлбар өгөхгүй юу. Хоёрдугаарт, оффшор бүсэд 23 төрийн албан хаагчийн нэр байгаа. Эдгээр хүмүүсийн нэрийг яагаад зарлахгүй байгаа юм бэ? Зарлах нь хуулиараа нээлттэй биз дээ? Гуравдугаарт, авлигын индексээр манай улс 87 дугаар байрт орсон гэсэн. Энэ бол худал мэдээлэл гээд байгаа юм. Бүр хойшоо зуу гаруй руу орсон байгаа гэсэн мэдээлэл байгаа юм. Энэ асуултуудад хариулт өгнө үү.

Мөрдөн байцаах албаны дарга, ахлах комиссар Н.Дамдинсүрэн: -Эхний асуултуудад хариуль. 60 тэрбумын гэх тодотголтой хэрэг дээр Улсын ерөнхий прокурорын тушаалаар Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэсээ цагдаа болон

тагнуулын байгууллагатай хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж ажилласан. Ажлын хэсэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд ажиллаад Нийслэлийн прокурорын газарт хянуулахаар хүргүүлсэн. Прокурорын байгууллага хэргийг хянаад шийдвэрээ гаргасан. Үүн дээр нийслэлийн прокурорын газраас дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.

Хоёрдугаарт, оффшор бүсийн асуудлаар яг одоогоор хэрэг бүртгэлтийн хэрэг нээгээд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу прокуророос бүх зөвшөөрлийг авсны үндсэн дээр иргэдэд мэдээллийг бид өгнө. Гэхдээ энэ мэдээлэл нь 2016 оны 4 дүгээр сард Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн байгууллагаас нийтэд мэдээлэгдсэн. 23 хүнийг шалгаж байгаа. 29 хүн байгаа. Төрийн албан хаагч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээд гээд 23 хүн дээр хэрэг бүртгэлтийн ажиллагаа явж байгаа.

Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням: -Транспэрэнси интернэшнл олон улсын байгууллагаас гаргадаг индексийн тухай асууж байна гэж ойлголоо. Энэ дээр зуу гаруйд орсон байсныг зохиомлоор наян хэд болгоод худал мэдээллийг нийтэд танилцуулах нь бидний хувьд боломжгүй.

Төгсгөл нь IV нүүрт

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

3.БААСАННЯМ: МАНАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖИЙГ ХҮЛЭЭН АВЧ ХАМТРАН АЖИЛЛАХАД ТАТГАЛЗАХ ЗҮЙЛ БИДЭНД БАЙХГҮЙ

Төгсгөл. Түрүүч нь III нүүрт

Энэ нь биднээс үл шалтгаалдаг ажил. ТИ байгууллагаас олон улсын шинжээчдийн өгсөн дүгнэлтээр гаргадаг үзүүлэлт. Оноог өгөхдөө 11-13 шалгуур үзүүлэлтээр дүгнэдэг. Онооны дарааллаар нь улс орнуудыг байр эзлүүлээд олон улсад зарладаг. Дэлхий нийтэд нэгэн ижил очиж байгаа мэдээллийг бид ямар нэгэн байдлаар хойш урагш нь ухрааж өөрчлөх боломж байхгүй. Авлигын индексийг тогтоож байгаа үндэслэлүүд нь тухайн улс орны төр, засгийн түвшинд авлигатай тэмцэх бодлого, улс төрийн хүсэл зоригийг илтгэдэг. Түүнээс тухайн улсын авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаанд өгч байгаа үнэлэлт дүгнэлт биш.

NTN телевиз: -АТГ-ын дэргэд Олон нийтийн зөвлөл шинээр байгуулагдсан. Та бүхэн уулзаж ярилцсан. Зөвлөлөөс шинэ журам гаргасан байна лээ. Энэ журамтай та нар танилцсан уу? Миний авсан мэдээллээр бол энэ журам хуулиас давсан агуулгатай гэж байгаа. Үүнд тайлбар өгөхгүй юу?

Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням: -АТГ-ын дэргэд орон тооны бус Олон нийтийн зөвлөл ажиллах хуулийн зохицуулалттай. Энэ зөвлөлийн ажиллах журмыг Авлигын эсрэг хуульд тодорхой заасан байгаа. Ямар үйл ажиллагаа явуулах вэ гэдгийг нь. Авлигын эсрэг иргэдийн санал бодлыг хүргэх, эдгээртэй холбоотой зөвлөмж хүргүүлэх гээд үүргүүд нь хуульд бий. Үүнтэй холбогдуулан авлигын эсрэг хууль тогтоомжийг Авлигатай тэмцэх газар хэрхэн хэрэгжүүлж байгааг хянах, гэхдээ үүнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, гүйцэтгэх ажлаас бусад үйл ажиллагаа гээд заасан. Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хянана гээд заасан байгаа. Өнгөрсөн долоо хоногийн пүрэв гарагт АТГ-ын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журмыг Ерөнхийлөгч баглаад ирүүлснийг эх хувиар нь хүргүүлж гардуулсан. Бид журамтай танилцаж байна. Энэ хурлын дараа Олон нийтийн зөвлөл мэдээлэл хийнэ. Та бүхэнд журмын талаар мэдээллээ өгөх байх. Бид журамтай танилцаад хэрвээ хуулиас давсан, бусад байгууллагын эрх хэмжээний хүрээнд хийгдэх ажлуудыг өөртөө хамаатуулж авч хийхээр ч гэдэг юм уу, байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс хэт нөлөөлж оролцохуйц заалтууд байвал бид энэ тухай саналаа тодорхой түвшинд нь хүргүүлэх арга хэмжээ авч болно.



NTN телевиз: -Олон нийтийн зөвлөлөөс АТГ-ын төсөв санхүүг хянана гэдгээ мэдэгдээд байгаа. Энэ нь хэр үндэслэлтэй вэ? Олон нийтийн зөвлөлд ийм үүрэг байдаг уу?

Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням: -Шууд байгууллагын санхүү төсвийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох эрх хуулиараа байхгүй. Авлигын эсрэг хуульд Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд хувь хүн, байгууллага хөндлөнгөөс оролцохыг хориглоно гэж заасан байдаг. Гэхдээ үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр өгч байгаа зөвлөгөө, зөвлөмжийг хүлээн авч хамтран ажиллахад татгалзах зүйл бидэнд байхгүй. Манай байгууллагын төсөв санхүүгийн мэдээлэл Шилэн дансны буландаа байнга ил тод, нээлттэй тавигдсан байгаа. Бүтэн жилийн санхүүгийн үйл ажиллагааг аудитын байгууллага жил бүр 2 удаа гүйцэтгэлийн болон хяналтын шалгалтаа хийгээд явдаг. Дүгнэлт гаргадаг. Манай байгууллагын хувьд 2007 оноос хойш жил бүрийн аудитын дүгнэлтээр ямар нэгэн зөрчилгүй гэсэн дүгнэлт гардаг. Бид Олон нийтийн зөвлөлдөө аудитын байгууллагын жил бүрийн шалгалтын тайлан, дүгнэлтийг хүргүүлэх нь чөлөөтэй. Манай төсөв санхүүгийн мэдээлэл байгууллагын цахим хуудсанд сар тутмаараа тавигддаг. Та бүхэн ч бас чөлөөтэй үзэж танилцахад нээлттэй.

“Өдрийн сонин”: -Олон нийтийн зөвлөлийн дарга Г.Баасангаа та нар байгууллагынхаа хаалгаар нэвтрүүлэггүй гэсэн. Яагаад оруулаагүй юм бэ?

Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн

комиссар З.Баасанням: -Тэр өдөр авлига, мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр олон улсын хурал, сургалт болсон. Тэр өдөр мөн Ард түмний онц зөвлөл гэдэг байгууллага манай А байрны урд жагсаал хийсэн. Авлигатай тэмцэх газрын байр нь төрийн тусгай хамгаалалтад байна гээд хуулийн заалттай. Төрийн тусгай хамгаалалтын албан хаагчид А байрны нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлахтай давхцсан байсан. Миний авсан мэдээллээр, Олон нийтийн зөвлөлийн гишүүд маань буруу хаалгаар нэвтрэх гээд очсон юм билээ. Та бүхэнд хэлэхэд, Авлигатай тэмцэх газар Олон нийтийн төвтэй болсон. А байрны буюу төв хаалгаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд холбоотой хүмүүс нэвтрэхээр дотоод журамтай. Харин Олон нийтийн төвийн хаалгаар бусад иргэдийг нэвтрүүлнэ. Баасан даргыг оруулахгүй, нэвтрүүлэхгүй гэсэн асуудал байхгүй.

-Ард түмний онц зөвлөлөөс шаардлага тавьж байгаа. Авлигатай тэмцэх газрыг ажлаа хангалтгүй хийж байгаа гэж шүүмжилсэн. Энэ дээр та бүхэн ямар тайлбар өгөх вэ?

Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням: -Бид ардчилсан нийгэмд амьдарч байгаа. Жагсах, цуглах, үзэл бодлоо илэрхийлэх, үгээ хэлэх, шаардлага тавих нь хүний эрхийн асуудал. Бид үүнд эмзэглэхгүй. Ажилд хэрэг, нэмэр болох санал, зөвлөмжийг бид хүлээж авна. Болмжгүй зүйлд боломжгүй гэсэн хариуг бас өгнө. Ардчилсан нийгэмд эрхээ эдэлж байгаа иргэдэд ямагт хүндэтгэлтэй хандана.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Батлан хамгаалах яаманд хийсэн шалгалтын дүнг хэлэлцэв

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газраас байгуулагдсан ажлын хэсэг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабт ажилласан дүнгээ хэлэлцүүлээ.

Дүнг хэлэлцүүлэхэд Төрийн албаны зөвлөл, Үндэсний Аудитын газрын болон Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабын удирдах албан тушаалтнууд, мэргэжилтнүүд оролцсон юм. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Т.Баярхүүгээр ахлуулсан ажлын хэсэг Батлан хамгаалах яаманд ажиллах явцдаа албан тушаалтнуудаас гаргасан хууль бус шийдвэр, албан тушаалын томилгоо, тендер сонгон шалгаруулалт, худалдан авах ажиллагаатай холбоотой нэлээд зөрчил, дутагдал илрүүлжээ.

Тус яамны 2015 оноос хойшхи үйл ажиллагаатай танилцахад тендер сонгон шалгаруулахдаа хууль зөрчин шууд гэрээ байгуулдаг, нэр бүхий цөөн тооны компаниуд байнга сонгон шалгаруулалтад оролцож шалгардаг, худалдан авах ажиллагааг хэн нэгэн албан тушаалтны хувийн үзэмжээр шийдвэрлэдэг, бусдад давуу байдал олгодог, хуулийн заалтыг буруу хэрэглэдэг, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулахгүйгээр томилдог зэрэг зөрчил илэрсэн байна.

Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал илэрсэн зарим зөрчил, дутагдлыг цаашид гүнзгийрүүлэн шалгах чиглэлээр 2 ажлын хэсэг гарган ажиллахыг даалгав. Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Авлигатай тэмцэх газрын даргын хамтарсан тушаалаар батлагдсан журмын дагуу Олон нийтийн дэд зөвлөлийг ажилд нь нэн яаралтай оруулахыг үүрэг болголоо. Ингэснээр тус яамны үйл ажиллагааг иргэд, олон нийт хянах боломжтой болох юм.

Хэлэлцүүлгийн төгсгөлд Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батбилэг “Авлигатай тэмцэх газрын ажлын хэсгийн ажилласан тайлангийн дүнгийн мөрөөр, энэ хэлэлцүүлгээс гарсан санал, шүүмжлэл нэг бүрийг бид цаашид үйл ажиллагаандаа анхаарч хэрэгжүүлж ажиллах болно. Санаатай гэхээсээ илүү санамсаргүй, хуулийн мэдлэггүйгээс болж алдах явдал байна. Тиймээс Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтарч ажиллаа”

гэж хэллээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд ажилласан дүнг хэлэлцэв

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон түүний харьяа агентлагуудад ажилласан дүнгээ Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг тус газрын “Олон нийтийн төв”-д хэлэлцүүлээ.

Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалтын албаны дарга, ахлах комиссар Л.Сүх-Очирын ахалсан ажлын хэсэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2015-2017 оны хугацаанд авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрхэн хэрэгжүүлсэнтэй танилцсан юм.

Яам, харьяа агентлагийн хувьд хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулахгүй этгээдийг албан тушаалд томилсон, халаа сэлгээ их хийгддэг, гадаад томилолтын зардлыг хэтрүүлж олгосон, төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэхдээ сонгон шалгаруулсан гэх боловч холбогдох баримт бичиг нь байгаагүй зэрэг зөрчил, дутагдал илэрчээ.

Тайланг хэлэлцүүлэхэд оролцсон Ерөнхий аудиторын зөвлөх А.Энхбат тус яаманд гүйцэтгэлийн аудитаар илэрсэн 4 төрлийн актыг танилцуулаад эдгээр нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй тул асуудлыг шалгуулахаар Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст шилжүүлж байгаагаа мэдэгдлээ.

Зам тээврийн салбарт ажилласан дүнг хэлэлцүүлэв

Авлигатай тэмцэх газраас томилогдсон ажлын хэсэг Зам тээврийн хөгжлийн яаманд ажилласан тайлангаа өнөөдөр хэлэлцүүлээ. Тайланг хэлэлцүүлэхэд Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо, Улсын ерөнхий аудиторын зөвлөх А.Энхбат болон Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ, тус яамны газар, хэлтсийн дарга нар, харьяа агентлагийн удирдах албан тушаалтнууд оролцлоо.

Авлигатай тэмцэх газрын Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга, ахлах комиссар Ц.Цэцэгдэлгэрэхээр ахлуулсан ажлын хэсэг Зам тээврийн

хөгжлийн яам болон түүний харьяа агентлагуудын 2015 оноос хойшхи үйл ажиллагаатай танилцсан юм.

Мөн салбарын хэмжээнд 5 хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулахгүй албан тушаалд томилсон, яамны ажилтан, албан хаагчдын үр дүнгийн гэрээний урамшуулалд 2015-2016 онд 508 сая төгрөг зарцуулсан, ИНЕГ-г сүүлийн 3 жилийн хугацаанд удирдах болон гүйцэтгэх албан тушаалд нийт 469 албан хаагчийг ямар нэгэн сонгон шалгаруулалт зарлалгүйгээр шууд томилсон, тус салбарт боловсон хүчний халаа сэлгээ ихтэй, хувь хүний үзэмж болоод улс төр, намын харьяаллыг харгалзан томилох асуудал их гардаг, тендер шалгаруулалтыг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулсан нь худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн, зарим нэр бүхий тендерт өөр хоорондоо холбоо хамааралтай хоёр компанийг оролцуулсан байж болзошгүй, “Монголын хөлөг онгоцны бүртгэл” ХХК-ийн орлого төвлөрүүлэлт, зарцуулалт, гэрээний үүргийн биелэлтэд тавих хяналт сул, чиг үүрэг, статус нь тодорхойгүй байх тул холбогдох асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэх талаар Ажлын хэсгээс танилцууллаа.

Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо “Энэ мэт хууль зөрчсөн үйлдлүүдийг залруулах ёстой. Төрийн захиргааны албан тушаалд 9 хүн гэрээгээр ажиллаж байгаа нь төрийн албаны сонгон шалгаруулалтын зарчмыг зөрчсөн үйлдэл. Ийм явдал байж болохгүй. Авлигатай тэмцэх газрын ажлын хэсгүүдээс гаргасан санал, зөвлөмж, шийдвэрийг Төрийн албаны зөвлөл цаашид өөрийн хамаарах ажил үүргийн хүрээнд анхаарч, хамтран хэрэгжүүлэх болно. Төрийн албаны зөвлөл Авлигатай тэмцэх газар шиг ингэж төрийн бүх байгууллагууд руу орж ажиллахаар төлөвлөж байгаа. Энэ ажлыг эсэргүүцэж болохгүй. Энэ бол та нөхдийг хууль зөрчиж гэмт хэрэгт холбогдохоос сэргийлж байгаа арга хэмжээ шүү” гэж хэлэв. Ерөнхий аудиторын зөвлөх А.Энхбат “Зам тээврийн салбарт хуулиас давсан журам үйлчлэлд байна. Яам болон агентлагийн 2015, 2016 оны төсвийн гүйцэтгэлд аудит хийсэн. Төсөв хэтэрсэн, хэтрүүлсэн асуудал байгаа. Хууль бусаар ажлаас халагдсан хүмүүсийн нөхөн олговорт 155.2 сая төгрөг зарцуулсан байдаг. Энэ мэт зөрчил олон байгаа учраас танай салбарт тусгайлан санхүүгийн болон эрсдлийн аудит хийх болно” гэлээ.

Шинээр байгуулагдсан Олон нийтийн ЗӨВЛӨЛИЙН гишүүдтэй уулзав

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн дарга, гишүүдтэй хийх анхдугаар уулзалт тус газрын Олон нийтийн төвийн байранд болов.

Уулзалтад Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал, дэд дарга, эрхэлсэн комиссар Ц.Нямдорж, Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасаням, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Т.Баярхүү, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Х.Хашбаатар болон албадын дарга, ахлах ажилтнууд оролцлоо.

Авлигатай тэмцэх газрын дэргэд 4 дэх удаагаа байгуулагдаж байгаа Олон нийтийн зөвлөлийн бүрэлдэхүүнд “Легитимус” ТББ-ын хуулийн зөвлөх, хуульч Б.Анхныбаяр, Монголын хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч Г.Баасан, “Шинэ Улаанбаатар” ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Э.Багсуурь, Улс төр боловсролын академийн Удирдах зөвлөлийн гишүүн Р.Бурмаа, “Нарны зон” НҮТББ-ын тэргүүн Э.Бямбацэрэн, “Хамтын халуун сэтгэл” ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Б.Ганхөлөг, “Алтан элч” гэр бүлд эрх зүйн туслалцаа үзүүлэх төв ТББ-ын тэргүүн Д.Дэлгэрбат, Монголын малчид, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн холбооны тэргүүлэгч И.Мөнхжаргал, Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүн Д.Оросоо, Техник, загвар зохион бүтээгч спортын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн С.Отгонгэрэл, “Нутгийн шийдэл сан” ТББ-ын тэргүүн, ном зохиогч Ц.Оюунгэрэл, Монголын хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч Д.Пүрэвбаатар, “Шууд ардчилал хүрээлэн” ТББ-ын захирал А.Саруул, МоАХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн О.Цоодол, “Либерал хаус” бодлогын судлалын хүрээлэнгийн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Энхбат нар томилогдсон байна.

Олон нийтийн зөвлөлийн гишүүнээр ял шийтгэлгүй, иргэний нийгмийг төлөөлөх иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч 4 жилийн хугацаагаар томилдог. Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөл нь авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд зөвлөмж өгөх зорилготой юм.



СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ

2017 ОНЫ 8 ДУГААР САРД: НИЙТ 577 ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖЭЭ

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ээ Авлигатай тэмцэх газраар хянуулах үүрэгтэй билээ. Энэ хүрээнд хянуулахаар ирүүлж буй ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газар хэрхэн шийдвэрлэдэгт тус газрын Судалгаа шинжилгээний албанаас сар тутмаар дүн шинжилгээ хийж танилцуулдаг байна. 2017 оны 8 дугаар сард Авлигатай тэмцэх газрын хянан шийдвэрлэсэн ХАСУМ-ийн талаарх мэдээллийг тоймлон хүргэе.

Авлигатай тэмцэх газарт 2017 оны 8 дугаар сард 509 мэдүүлэг хүлээн авч, өмнөх сарын үлдэгдэлтэй нийт 577 мэдүүлгийг хянан шийдвэрлэжээ. Ирүүлсэн мэдүүлгийн тоог байгууллагаар нь авч үзвэл Цагдаагийн ерөнхий газар 68, аймаг, нийслэл, сум,

дүүргийн Засаг даргын Тамгын газар 88, Хил хамгаалах ерөнхий газар 31, Онцгой байдлын ерөнхий газар 30, Гадаад харилцааны яам 23, Зэвсэгт хүчний жанжин штаб 23, Төрийн банк 20, Оюуны өмч, улсын бүртгэлийн газар 18 мэдүүлэг тус тус ирүүлсэн нь хамгийн олон болж байна. Энэ нь дээр нэр дурдсан салбар, байгууллагуудад 2017 оны 8 дугаар сард хамгийн олон томилгоо, шилжилт хөдөлгөөн хийгдсэн гэсэн үг юм.

Тэгвэл аймаг, нийслэлээр нь авч үзвэл Улаанбаатар хотод 484, Дорнод, Сэлэнгэ аймагт тус бүр 9, Баянхонгор, Хэнтий, Хөвсгөл тус бүр 8, Орхон 7 мэдүүлэг тус тус ирүүлсэн нь хамгийн олон гэгдэж байна. Харин Баян-Өлгий, Архангай, Булган аймгаас харьцангуй цөөн тооны ХАСУМ ирүүлжээ.

2017 оны 8 дугаар сарын байдлаар төрийн тусгай албан тушаалд 225, төрийн захиргааны албан тушаалд 148, төрийн үйлчилгээ 90, төрийн өмчийн оролцоотой

хуулийн этгээд 52, төрийн улс төрийн албан тушаалд 45 мэдүүлэг ирүүлсэн нь хамгийн өндөр дүн юм. Эдгээрийн 270 нь удирдах, 7 нь бусад албан тушаал байгаа бол 300 нь гүйцэтгэх албан тушаал байна.

Авлигатай тэмцэх газар 2017 оны 8 дугаар сард ХАСУМ-ийг дараах байдлаар шийдвэрлэжээ. Тухайлбал, ашиг сонирхлын зөрчил үүсээгүй 86.7, ажлын байрны тодорхойлолт болон хуульд заасан шаардлага хангаагүй 6.4, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсныг анхааруулсан 2, томилсон тушаал, захирамжийг хүчингүй болгуулахаар буцаасан 2, томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлээгүй 1.1, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал бий болсон 0.7, холбогдох материал дутуу 0.7, хуулийн үйлчлэлд хамаарахгүй болон ашиг сонирхлын зөрчил илт үүсэх нөхцөл байдал тогтоогдсон 0.2 хувийг тус тус эзэлж байв.

АЛБАН ТУШААЛАА УРВУУЛСАН, ХЭТРҮҮЛСЭН ГЭХ ГОМДОЛ ХАМГИЙН ОЛОН ИРЖЭЭ

-АТГ-т ирсэн өргөдөл, гомдол, мэдээллийн нэг сарын дүр зураглал-

Авлигатай тэмцэх газар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авдаг бөгөөд тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаар сар бүр дотооддоо дүн шинжилгээ хийдэг. Ийнхүү дүн шинжилгээ хийх нь энэ чиглэлийн ажлын үр дүнгээ тооцох, цаашид улам сайжруулахад анхаарах асуудлаа тодорхойлоход ач тустай ажээ. Энэ удаа 2017 оны 8 дугаар сард хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх дүн шинжилгээний мэдээллийг нэг өгүүлбэрээр танилцуулья.

- 2017 оны 8 дугаар сард АТГ нийт 67 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авчээ.
- Өргөдөл, гомдол, мэдээллийн дийлэнхийг иргэд биеэр ирж өгчээ.
- Хүлээн авсан 67 өргөдөл, гомдол, мэдээллийн 44-ийг Улаанбаатар хотоос ирүүлсэн нь хамгийн олон байна.
 - Сэлэнгэ, Төв, Хэнтий аймгаас тус бүр 3, Архангай, Ховд, Дорнод аймгаас тус бүр 2, Дорноговь, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь, Орхон аймгаас тус бүр 1 өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн байв.
 - Сүхбаатар, Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Увс, Хөвсгөл, Дархан-Уул аймгаас өргөдөл, гомдол, мэдээлэл ирээгүй байна.
 - 46 өргөдөл, гомдол, мэдээллийн агуулга нь гэмт хэргийн шинжтэй, 20 нь ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой байжээ. Төрийн байгууллагын ёс зүй, хүнд суртал, удирдах ажилтны гаргасан шийдвэртэй холбоотой 1 мэдээлэл байв.
 - Цагдаа, боловсрол, газрын харилцаа, кадастр, нутгийн удирдлага, гааль, шүүх, эрүүл мэндийн салбар, байгууллагатай холбоотой өргөдөл, гомдол, мэдээлэл 2017 оны 8 дугаар сард давамгайлжээ. Нийт өргөдөл, гомдол, мэдээллийн 22.4 хувь нь цагдаа, 11.9 хувь нь боловсролын салбарт хамаарч байна.
 - Сургуулийн өмнөх боловсрол, газар олголт, бүртгэл, тендер, гаалийн хяналт, нутгийн өөрөө удирдах байгууллага, замын цагдаагийн үйл ажиллагаатай холбоотой гомдол олон ирсэн дүнтэй байна.
 - Албан тушаалаа урвуулсан, хэтрүүлсэн гэх гомдол хамгийн олон байв.
 - АТГ иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 2017 оны 8 дугаар сард хүлээн авсан 67 өргөдөл, гомдол, мэдээллийн 32-ыг нь шийдвэрлэсэн байна.
 - Гэмт хэргийн шинжтэй 1 гомдолд эрүүгийн хэрэг үүсгэсэн бол 4 өргөдөл, гомдол, мэдээллийн зөрчлийг тогтоож шийдвэрлэжээ. Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, мэдээллийн 8-д нь зөрчил илрээгүй тул хаасан байна.

БАЙР СУУРЬ

ХЭН ЮУ ХЭЛЭВ?

Авлигатай тэмцэх газрын санаачилгаар Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурорууд, Авлигатай тэмцэх газрын болон Цагдаагийн ерөнхий газрын мөрдөгч нар, мөн Монголбанкны санхүүгийн мэргэжилтнүүдэд зориулан зохион байгуулсан “Олон улсын болон үндэсний хэмжээнд авлига, мөнгө угаах явдалтай тэмцэх нь” сургалтын үеэр хүмүүсийн хэлсэн үгсийг онцолж байна.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Эдийн засгийн зөвлөх Роел Жансенс:



-Манай байгууллага 57 орны гишүүнчлэлтэй. Монгол Улстай авлигатай тэмцэх чиглэлээр хамтран ажиллах хүрээнд ахиц гарсан гэж үздэг. Монгол Улсын хувьд төрийн албан хаагчийн гадаад оронд оффшор данс, компани эзэмшихийг хориглох чиглэлд нэлээд ахицтай ажиллаж байна гэж дүгнэлээ. Цаашлаад залилангийн гэмт хэрэгтэй хэрхэн тэмцэж байгаа чиглэлээр Их Британийн туршлагыг судална. Мөнгө угаах нь нарийн түвэгтэй бөгөөд нэг улс дангаараа тэмцээд дийлэхгүй явдал. Олон улсын төдийгүй олон талын хамтын ажиллагаа байдаг учраас прокурор, Авлигатай тэмцэх газар болон цагдаа, мөн Төвбанкны албан хаагчдад энэ сургалтыг зориулж байгаа юм.

УПЕГ-ын Хяналтын прокурор Г.Оюунболд:

-Шинэ эрүүгийн хууль, холбогдох тогтоомжийг батлаад



хоёр сар гаруйн хугацаа өнгөрчээ. Авлига, мөнгө угаах зэрэг эдийн засгийн гэмт хэргийг уг хуульд шинээр оруулсан. Хуулийн хэрэгжилтийн хувьд дөнгөж эхэлж байгаа учраас хуульч, хууль сахиулагчдыг чадавхжуулах зайлшгүй шаардлагатай байна. Ялангуяа мөрдөх ажиллагаа болон бусад мэргэжилтний ур чадварыг сайжруулах ёстой. Эрх зүйн орчны хувьд орчин үеийн гэрээ конвенц, бусад хууль тогтоомж нь нэлээд тодорхой болсон. Энэ онд баталсан эрүүгийн хуулиар хуучин социалист чиг баримжаатай байсан аж ахуйн эсрэг хэрэг гэдэг зүйл эдийн засгийн эсрэг гэмт хэрэг болсон. Тэгэхээр дэлхий дахинд онцлон ярьж буй эдийн засгийн болон шинэ төрлийн гэмт хэрэгтэй манай мэргэжилтнүүд тэмцэх чадвартай байх ёстой.

Хамгийн гол нь уг хэргийг нотлох ур чадварыг нь сайжруулж байж бид нууц далд аргаар үйлддэг эдийн засгийн хэргийг шударга ёсны шүүлтүүрээр оруулна. Наад зах нь мөнгө угаах, терроризм, авлигатай тэмцэх

чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагууд хаана, хэрхэн ханддаг талаар ойлголттой байх ёстой юм. Өөрөөр хэлбэл, дам сургаар ярьдаг бус нотолдог ур чадвараа сайжруулах шаардлагатай.

Интерполын Авлигын гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээний мэргэжилтэн Эрнесто Андрес:



-Эдгээр гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн чухал алхам бол урьдчилан сэргийлэх асуудал, олон улсын хамтын ажиллагаа байдаг. Тухайлбал, манай Интерпол байгууллага нь мэдээлэл солилцох орчин нөхцөлийг бүрдүүлсэн. Энэ орчныг ашиглан улс орнууд мэдээлэл солилцох боломжтой. Мөнгө угаах явдал нь олон улс оролцсон нарийн түвэгтэй асуудал байдаг. Маш их цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулсан ажил. Тэр дундаа гадаад улс оронд мөрдөн байцаалт явуулна гэдэг амаргүй. Энэ ажлыг амжилттай хийхийн тулд мэдээлэл солилцох, олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, сургалт зохион байгуулах, хамтран ажиллах нь маш чухал юм.

Оффшор бүс дэх хөрөнгийг хэн дуртай нь очоод авчихдаг асуудал биш. Учир нь энэ хөрөнгө бол өөрөө нуусан хөрөнгө. Эзэн нь нууж хадгалах зорилготой хийсэн учраас нэг улсын ерөнхийлөгч хүслээ гээд улсынх нь иргэдийн мэдээллийг ил болгочихдог асуудал биш.

Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням:



-Оффшор бүсээс та бүхэн хөрөнгөө сайн дураар оруулж ирээч ээ гэхээс илүү тухайн бүсэд байгуулсан компани, байршуулсан хөрөнгийг оруулж ирэх, царцаах нь дан ганц манай улсын хууль тогтоомжоор хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа тул олон улсын ижил төстэй байгууллагуудаас мэдээ мэдээллийг түргэн шуурхай авч солилцох, нотлох баримтын хэмжээнд үнэлүүлэх, улмаар асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх гэсэн гарцыг хайж бид энэ төрлийн сургалтыг зохион байгуулж байгаа юм. Энэ үеэр гадагшаа хулгайлагдсан хөрөнгийг хэрхэн буцаан авчрах вэ, олон улсын байгууллагууд хэрхэн хамтран ажиллах вэ, мэдээллээ ямар байдлаар солилцох боломжтой вэ, авч болох сувгуудыг нээж, өөрсдөдөө ашигтайгаар эргүүлэх боломж байна уу гэх мэтээр ярилцаж байна.

Эрүүгийн хэрэг дээр харилцан тусалцах эрх зүйн харилцан тусалцааны гэрээг улс хооронд, Засгийн газрын түшинд байгуулах шаардлага нэн түрүүнд тавигдаж байна. Тухайн улс орноос мэдээлэл авъя гэхэд эрх зүйн харилцан тусалцааны гэрээний үндсэн дээр та бүхэнтэй харилцана аа гэдэг. Тэр гэрээ нь хоёр улсын хооронд байгуулагдаагүй тохиолдолд тодорхой хэмжээний гацаа үүсгэх гэдэг юм уу хүндрэл бэрхшээл болох асуудал бий.